



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 20-ны өдөр

№ 23

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-г тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - 2.1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төсвийг батлах;
 - 2.3. Гадаад валют арилжаа эрхлэхтэй холбоотой Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлах;
 - 2.4. Компанийн “Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” батлах;
 - 2.5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б. Буд/-д үүрэг болгосугай;
5. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар”-ыг энэхүү тогтоолын Нэгдүгээр Хавсралтаар баталж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз болон Компанийн цахим хуудсаар дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, зарын давталтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдрүүдэд анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй;

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар баталж, баримт бичгийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчид үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б. Буд/-д үүрэг болгосугай;
7. “Саналын хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын Гуравдугаар хавсралтаар баталсугай;
8. Компанийн бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс хойш Компанийн төв оффист ирж Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/, болон Хурал зохион байгуулах комисс /Ц.Алтаннавч/-г даалгасугай;
9. Үнэт цаасны брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Саналын хуудас”-аар урьдчилан санал авах хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 16:00 цагт тасалбар болгохоор тогтоосугай;
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар “Инвескор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-г томилсугай;
11. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:
 - 11.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:
Ц.Алтаннавч Үйл ажиллагаа хариуцсан захирал
 - 11.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Б.Буд	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Б.Тэмүүлэн	Маркетингийн ахлах менежер
Б.Цэрэннадмид	Маркетингийн менежер
Т.Номуундарь	Харилцагчийн үйлчилгээний менежер
В.Булгандаваа	Харилцагчийн үйлчилгээний менежер
Б.Алтанзагас	Хүний нөөцийн ахлах менежер
Б.Мөнх-Эрдэнэ	Үйл ажиллагаа хариуцсан ахлах менежер
М.Энхжин	Хуулийн зөвлөх
Э.Билгүүн	Хуулийн зөвлөх
А.Түвшинжаргал	СУХЗГ-ын захирал
О.Төгөлдөр	Цахим хөгжил хариуцсан захирал
Б. Номинхүү	Төслийн менежер
Б.Ихтамир	Ахлах нягтлан бодогч
12. Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:
 - 12.1. Тооллогын комиссын дарга:
Ж. Азбаяр “Инвескор Капитал ҮЦК” ХХК
 - 12.2. Тооллогын комиссын гишүүд:

Б. Ундрал	“Инвескор Капитал ҮЦК” ХХК
М. Энхцацрал	“Инвескор Ассет Менежмент ҮЦК” ХХК

Б.Энхжин

Дотоод аудитор

13. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б. Буд/, Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



"ИНВЕСКОР ББСБ" ХК

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03-р сарын
20-ны өдрийн хурлын 23 тоот Тогтоолын Тэгдүүлэгч хэргийн

invescore
FINANCIAL INSTITUTION

6060854 1119286063
УЛААНБААТАР ХОТ

**"ИНВЕСКОР ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

Компанийн оноосон нэр:	Инвескор ББСБ ХК
Хурлын төрөл:	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр, 14:00 цагт
Хурал хуралдах газар:	Компанийн веб хаяг болон Инвескор Апплекейшнаар дамжуулан цахим хэлбэрээр
Бүртгэлийн өдөр:	2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр
Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:	<ol style="list-style-type: none">Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төсвийг батлах;Гадаад валют арилжаа эрхлэхтэй холбоотой Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлах;Компанийн "Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр" батлах;Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:	<p>Хувьцаа эзэмшигчид нь 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон Компанийн төв байранд ирж хурлын баримт бичигтэй танилцаж болно.</p> <p>Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:00-18:00 цагийн хооронд ажиллана.</p>
Хурал хуралдах шийдвэр гаргасан этгээд, шийдвэрийн огноо, дугаар:	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 23 тоот тогтоол.
Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн:	<p>Хурлын комиссын дарга: Инвескор ББСБ ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал, altannavch@invescore.mn, 9910-9257</p> <p>Хурлын комиссын гишүүд:</p> <ol style="list-style-type: none">Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Буд, bud@invescore.mn, 8802-8974Маркетингийн ахлах менежер, Б.Тэмүүлэн, temuulen@invescore.mn, 88000-6848Маркетингийн менежер, Б.Цэрэннадмид, tserennadmid.b@invescore.mn, 8000-4354Харилцагчийн үйлчилгээний менежер, Т.Номуундарь, nomuundari@invescore.mn, 8000-4393Харилцагчийн үйлчилгээний менежер, В.Булгандаваа, bulgandavaa@invescore.mn, 8000-7387

6. Хүний нөөцийн ахлах менежер, Б.Алтанзагас, altanzagas@invescore.mn, 9904-6884
7. Үйл ажиллагаа хариуцсан ахлах менежер Б. Мөнх-Эрдэнэ, munkherdene.b@invescore.mn, 80001326
8. Хуульч, М.Энхжин, enkhjin@invescore.mn, 8582-5855
9. Хуульч, Э.Билгүүн, bilguun.e@invescore.mn, 8000-7334
10. Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал, А.Түвшинжаргал, tuvshinjargal.a@invescore.mn, 9999-1862
11. Цахим хөгжил хариуцсан захирал О.Төгөлдөр, tuguldur.och@invescore.mn, 8800-0076
12. Төслийн менежер, Б.Номинхүү, nominkhuu@invescore.mn, 8000-9553
13. Ахлах нягтлан бодогч, Б.Ихтамир, ikhtamir@invescore.mn, 8000-2638

"ИНВЕСКОР ББСБ" ХК

InvesCore

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн хурлын 23 тоот Тогтоолын Хоёрдугаар хавсралт

6060854 1119286063
УДАЛТАЙ ХОТ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн жагсаалт
1	"Инвескор ББСБ" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 23 тоот тогтоол;
2	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4	Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас;
5	"Инвескор ББСБ" ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан;
6	"Инвескор ББСБ" ХК-ийн 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
7	"Инвескор ББСБ" ХК-ийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дүгнэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол;
8	"Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийн санал;
9	Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр;
10	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл;

.....

**"ИНВЕСКОР ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн:

Овог: _____ Нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Бүртгэсэн Брокер, дилерийн компанийн нэр _____

Бүртгэсэн Брокерын овог, нэр _____

Энэхүү Саналын хуудсаар 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн 14:00 цагт Компанийн веб сайтаар болон Инвескор Апплекейшнаар дамжуулан цахимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;			
2.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах;			
3.	Гадаад валют арилжаа эрхлэхтэй холбоотой Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлах;			
4.	Компанийн "Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр" батлах;			
5.	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;			

Саналын хуудсыг ашиглах санамж:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь энэхүү саналын хуудсыг үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаж санал тэмдэглэн, үйлчлүүлдэг брокер, дилерийн компанид 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 16:00 цагаас өмнө хүргүүлнэ.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
- Засварласан, балласан, залруулгатай, болон нэгээс олон санал өгсөн саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Саналын хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурдана уу.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____ /гарын үсэг/
/тамга/Брокерийн гарын үсэг _____ /гарын үсэг/
/тамга/

2024 оны ____ р сарын ____ ны одор